



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 02 дугаар сарын 29

Дугаар 18/03

Баян-Өндөр сум

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн  
жилийн албан татварын хэмжээг хуульд  
нийцүүлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварын хэмжээг хуульд нийцүүлэн хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тогтоолыг Захиргааны ерөнхий хуульд заасан бүрдлийг хангаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, “Захиргааны хэм хэмжээний акт”-ын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Б.Ганзориг)-д даалгасугай.

3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэний дараа мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Түмэнжаргал)-д, татвар төлөгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах, татварын бааз суурийг нэмэгдүүлж, тэгш хамруулах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Галсансайнхувьт), аймгийн Татварын газрын дарга (Б.Цэвээнсүрэн)-т нарт үүрэг болгосугай.

4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

5.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн “Албан татварын хэмжээ батлах тухай” 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

C:My documents/togtool

6179100008

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн Ээлжит XVIII хуралдааны 18/03 дугаар тогтоолын хавсралт

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварын хэмжээ

Д/д	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл		Жилд ногдуулах албан татварын хэмжээ (төгрөгөөр)	
			Баян-Өндөр сум	Жаргалант сум
1	2 дугуйт мотоцикл		2500	2250
2	3 дугуйт мотоцикл		3750	3500
3	Суудлын автомашин: (цилиндрийн багтаамжийн нэг см <sup>3</sup> тутамд төгрөгөөр)	2001 см <sup>3</sup> хүртэл	20.0	17.5
		2001-3001 см <sup>3</sup> хүртэл	22.5	20.0
		3001 см <sup>3</sup> болон түүнээс дээш	27.5	25.0
4	Микроавтобус (15 хүртэл суудалтай)		42000	30000
5	Автобус		60000	42000
6	Ачааны автомашин	1 хүртэл тн-ын даацтай	31250	25000
		1-2 тн-ын даацтай	43750	35000
		2-3 тн-ын даацтай	56250	45000
		3-5 тн-ын даацтай	68750	55000
		5-8 тн-ын даацтай	100000	80000
		8-10 тн-ын даацтай	112500	90000
		10-20 тн-ын даацтай	150000	120000
		20-30 тн-ын даацтай	210000	180000
		30-40 тн-ын даацтай	270000	240000
		40-50 тн-ын даацтай	330000	300000
		50-60 тн-ын даацтай	420000	360000
		60-70 тн-ын даацтай	480000	420000
		70-80 тн-ын даацтай	540000	480000
		80-90 тн-ын даацтай	600000	570000
90-100 тн-ын даацтай	660000	630000		
		100 тн-оос дээш даацтай	720000	660000
7	Тусгай зориулалтын автомашин		24000	22500
8	Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл		21000	16800
9	Бага оврын трактор		10500	8400
10	Чиргүүл (даацын 1 тонн тутамд)		8250	8250
11	Цахилгаан тэжээлт автомашин		0	0